СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023 | X

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023
10 сар

Баруун-Урт сум

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал.

• Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- ‘Төл’ гэсэн нь төлөвлөгөө, ‘Гүйц’ гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII, VIII … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-VIII, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		
a^x	x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь		
▲▼	эерэг хандлага, эерэг өөрчлөлт	▲▼	сөрөг хандлага, сөрөг өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- мянга =1000
- сая $=10^6$
- тэрбум $=10^9$
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- мян. мянга
- % хувь
- кВт.ц киловатт цаг
- ккал килокалори
- $м^2$ метр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- ш ширхэг

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 2

Үндсэн үзүүлэлтүүд 5

I Хүн ам 6

II Хөдөлмөр 8

II Нийгмийн халамж 10

III Эрүүл мэнд 11

IV Гэмт хэрэг 14

V Мөнгө, банк 16

VI Орон нутгийн төсөв 18

VII Үнэ 19

VIII Хөдөө аж ахуй 24

IX Аж үйлдвэр 25

Хавсралт хүснэгтийн жагсаалт 29

Хавсралт хүснэгтүүд 30

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	С.Мөнхбаяр
I Хүн ам	С.Мөнхбаяр
II Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
V Гэмт хэрэг	Б. Сумьяа
VI Мөнгө, Банк	Б. Сумьяа
VII Орон нутгийн төсөв	Ц.Азжаргал
VIII.а Хэрэглээний үнэ	Б. Сумьяа
VIII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	С.Мөнхбаяр
IX Хөдөө аж ахуй	С.Мөнхбаяр
X Аж үйлдвэр	Э.Анхцэцэг

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

С.Мөнхбаяр

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 I-X	2022 I-X	2023 I-X
Төрсөн хүүхэд	хүн	1 187 6.1	901 -24.1	1 014 12.5
Нялхасын эндэгдэл	хүн	6 -50.0	7 16.7	4 42.9
Бүртгэлтэй ажилгүйчүүд	хүн	496 -2.4	426 -14.1	96 -77.5
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	12 765 28.8**	4 173 67.3	817 -80.4
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	301 -7.4	480 59.5	397 -17.3
Хэрэгт холбогсод	хүн	194 -22.4	335 72.7	238 -28.9
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	108.4 7.3	112.0 3.6	105.6 -6.4
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	139.0 17.8	130.1 -6.4	137.5 5.7
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	174.7 27.4	196.6 12.5	238.0 21.0
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	63.9 11.3	47.2 -26.1	61.1 29.4
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	66.0 13.2	41.1 -37.7	49.5 20.4
Хураасан ургац: - Төмс	тн	689.0 21.1	569.9 -17.3	106.8 6.8
- Хүнсний ногоо	тн	361.2 15.7	860.0 2.4**	1 034.9 20.3
- Үр тариа	тн	4 413.9 2.0**	3 478.0 -21.2	2 343.5 -27.1
- Тэжээлийн ургамал	тн	3 995.8 2.1**	1 767.0 -55.8	2 343.5 32.6
- Техникийн ургамал	тн	602.2 -41.0	810.0 34.5	645.0 -20.4
Ургац хураалт, хадлан: Өвс	тн	7 948.0 -25.4	5 663.4 -28.7	15 532.3 2.7**
- Гар тэжээл	тн	28.5 -83.2	10.5 -63.2	33.0 3.1**
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	124.4 20.5	140.4 12.8	188.0 33.9
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	206.0 40.7	300.8 46.0	384.3 27.8

Тайлбар: ** дахин

ХҮН АМ, жил бүрийн эхний 10 сард



Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 12.5 хувиар өсчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2023 оны эхний 10 сард 1010 эх амаржиж, 1014 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 106 (11.7%)-аар, төрсөн хүүхэд 113 (12.6%)-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 10 сард



1000 хүнд ногдох төрөлт 15.4 болж өмнөх оноос 1.7 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 10 сард



2023 оны эхний 10 сард нас баралт 248 болж, өмнөх оноос 12 (5.1%)-аар өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 15.4 хувь, нас баралт 3.8 хувь, ердийн цэвэр өсөлт 11.6 хувьтай байна. 1000 хүнд ногдох нас баралт 3.8 болж өмнөх оноос 0.2 нэгж хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР, бүртгэлтэй ажил хайгч иргэд

2023 оны 10 дугаар сард

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 35.2 хувиар өсчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2023 оны 10 дугаар сарын эцэст 96 болсны 50 (52.1%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 330 (77.5%) хүнээр, 2022 оны 12 дугаар сарын эцсээс 267 (73.6%) хүнээр тус тус буурсан байна.
Эхний 10 сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1264 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 409 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 78 (81.3%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 25 (26.0%) нь бакалавр, 1 (1.0%) нь тусгай мэргэжлийн дунд 6 (6.3%) нь мэргэжлийн анхан шат, 33 (34.4%) нь бүрэн дунд, 20 (20.8%) нь суурь, 7 (7.3%) нь бага, 4 (4.2%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшингээр, 10 сарын байдлаар

Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнө оноос 2137 (31.0%) хүнээр буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2023 оны эхний 10 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1483 хүн хамрагдсан нь өмнөх оноос 143 (10.7%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 4.1 тэрбум төгрөг болж 457.8 (12.5%) сая төгрөгөөр өссөн байна

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2023 оны эхний 10 сард 2482 хүн хамрагдсаны 50.7 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.3 хувь нь онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2.6 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 893.5 (52.0%) сая төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 10 сар

Үзүүлэлт	2021 I-X		2022 I-X		2023 I-X	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**26 497**	**9 310.8**	**26 976**	**9 285.4**	**25 931**	**10 711.0**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	9 220	5 918.4	6 952	5 693.4	5 086	6 886.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 256	3 580.8	1 340	3 656.8	1 483	4 114.6
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 179	1 649.5	2 299	1 717.7	2 482	2 611.2
Нийгмийн халамжийн үйлчилгээ	46	30.8	214	73.6	159	69.8
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	5 739	657.3	3 099	245.3	962	91.2
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 473	722.4	5 659	735.7	5 800	748.0
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 503	191.5	5 000	312.7	5 514	477.4
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	-	-	17	3.9	11	2.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	330	65.8	542	139.3	560	156.9
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 221	1 974.8	5 793	1 941.1	5 706	1 939.7
Насны хишиг	2 750	437.9	3 013	459.3	3 254	500.0

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтын үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн эхний 10 сард

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид



2022 I-X **12 170**

2023 I-X **13 465**

10.6% ↑

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2022 I-X **4 173**

2023 I-X **817**

80.4% ↓

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2022 I-X **7**

2023 I-X **4**

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2022 I-X **4**

2023 I-X **5**

2023 оны эхний 10 дугаар сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2023 оны эхний 10 сард 1010 эх амаржсан нь өмнөх оноос 106(11.7%)-аар өссөн байна. Нийт амаржсан эхийн 0.4 хувь нь гэртээ төрсөн байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 968 (95.4%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амалсан, 31 (3.0%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 10 сард

Үзүүлэлт	2021 I-X	2022 I-X	2023 I-X	2023 I-X / 2022 I-X
	тоо			хувь
Амаржсан эх	1 174	904	1 010	111.7
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	1 093	852	979	114.9
Гэрийн төрөлт	5	2	4	200.0
Амьд төрсөн хүүхэд	1 187	901	1 014	112.5
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	1 106	824	968	117.5
төрөлхийн гажигтай төрсөн	9	5	6	120.0
2500 граммаас доош жинтэй төрсөн	38	29	31	106.9
Амьгүй төрсөн хүүхэд	6	5	4	80.0
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	0.4	5.5	3.9	70.9

2023 оны эхний 10 сард нас баралтын 248 тохиолдол бүртгэгдсэний 47 (18.9%) нь осол гэмтлийн улмаас, 64 (25.8%) нь хорт хавдарын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 10 сард

Үзүүлэлт	2021 I-X	2022 I-X	2023 I-X	2023 I-X / 2022 I-X
	тоо			хувь
Нас баралт	306	236	248	105.1
Эмнэлгийн нас баралт	64	50	41	82.0
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	30	29	47	162.1
Хорт хавдрын өвчлөл нас баралт	97	75	64	85.3
0-1 насны эндэгдэл	6	7	4	57.1
1-5 хүртэлх насны эндэгдэл	1	4	5	125.0

Халдварт өвчнөөр өвлөгчид 2023 оны эхний 10 сард 817 болж, өмнөх оны мөн үеэс 3356(80.4%)-аар буурахад короновируст халдварын тохиолдол буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 10 сар

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2021 I-X	2022 I-X	2023 I-X	Өсөлт, бууралт	
					тоо	хувь
Бүгд	**хүн**	**12 765**	**4 173**	**817**	**-3 356**	**19.6**
Вируст гепатит	хүн	4	4	4	0	100.0
Гар хөл амны өвчин	хүн	19	51	119	68	2.3 [1]
Бруцеллёз	хүн	-	2	-	- 1	-
Цусан суулга	хүн	13	19	28	9	147.4
Салхинцэцэг	хүн	3	46	204	158	4.4 [1]
Энтервируст халдва	хүн	-	-	107	107	-
Гахайн хавдар	хүн	-	-	2	2	-
Улаан эсэргэнэ	хүн	-	-	14	14	-
Ёлом	хүн	-	-	1	1	-
Салмонеллт	хүн	-	-	19	19	-
Хачигт	хүн	-	-	4	4	-
Сүрьеэ	хүн	43	52	52	0	100.0
Тэмбүү	хүн	64	42	29	- 13	69.0
Трихомониаз	хүн	74	74	50	- 24	67.6
Заг	хүн	58	56	41	- 15	73.2
Ковид-19	хүн	12 487	3 827	143	-3 395	3.7

Харин салхинцэцгээр өвчлөгчид 204 (4.4 дахин)-аар, гар хөл амны өвчин 119 (2.3дахин)-аар нэмэгдэж, Коронавируст халдвараар өвчлөгчид 3395 (96.3%)-гөөр буурсан байна. Шинээр энтервируст халдвар 107, улаан эсэргэнэ 14, ёлом 1, салмонеллт 19, хачигт 4 өвчний халдварын тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 10 сарын байдлаар 229.4 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 27.8 (13.8%) мянган хүнээр өсч, 13.5 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 54.5 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 12.2 (23.7%) мянган хүнээр өсчээ.

Түргэн тусламжийн дуудлага 13.5 мянган удаа гарсны 2.6 (19.1%) мянга нь алсын дуудлага байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ГЭМТ ХЭРЭГ, 2023 оны эхний 10 сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2022 I-X	2023 I-X	
480	397	-17.3% ↓

Хөнгөн хэрэг
332

Хүнд хэрэг
65

Илрүүлэлтийн хувь
45.3%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
154

Нас барсан хүн
13

Хохирол сая төг
936.7

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
12

Согтуугаар
124

Ял шийтгэгдэж байсан
46

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 83 (17.3%)-аар буурсан байна.

2023 оны эхний 10-р сарын байдлаар 397 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 13 хүн нас барж, 154 хүн гэмтэж бэртсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 936.7 сая төгрөгийн хохирол учирсны 37.0 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 238 хүн холбогдон сэжиглэгдсэний 124 (52.1%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ. Бүлгээр үйлдсэн гэмт хэрэг 10 сард 12 болж өмнөх сараас 2 (16.7%) хүнээр өссөн байна.
Нийт 552 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 181 (32.8%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс 259 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.
Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 45.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.3 нэгжээр буурсан байна.

Зураг 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ, ЗЭЭЛ, 2023 оны 10 сард

Мөнгө, зээл

МОНГОЛБАНК

Нийт зээлдэгчийн тоо

2022 X **34 802**

2023 X **35 038**

Зээл 2023 X

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл **238.0** тэрбум төгрөг

1.8 тэрбум төгрөг Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл

1.5 тэрбум төгрөг Чанаргүй зээл

ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ 2023 X

Иргэдийн **137.5** тэрбум төгрөг

Хугацаатай **121.9** тэрбум төгрөг

Хугацаагүй **15.6** тэрбум төгрөг

BANK

Салбар нэгжийн тоо **35**

Ажилтнуудын тоо **207**

АТМ-ны тоо **33**

Карт эзэмшигчийн тоо **60 320**

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 10 сарын байдлаар 1.5 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 238.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 1.8 (0.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 41.4 (21.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 137.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сарын мөн үетэй ижил түвшинд, өмнөх оны мөн үеэс 7.4 (5.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт хадгаламжийн 88.6% нь хугацаатай, 11.4% нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАДАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 50.3 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2023 оны эхний 10 сарын байдлаар 61.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13.9 (29.4%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 49.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 8.4 (20.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төг



Аймгийн нийт төсвийн 40.7 хувийг орон нутгийн төсвийн орлого, 12.9 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 10.8 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 22.1 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 10.4 хувийг урьд оны үлдэгдэл, 3.1 хувийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Аймгийн төсвийн мэдээг Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар

2023 оны 10 дугаар сард



Тайлбар: Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.6 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 10 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.7 хувь, өмнөх оны эцсээс 5.6 хувь, өмнөх сараас 0.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 10 дугаар сар өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 7.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 9.0 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 5.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 3.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 12.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.1 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн дүнгээрээ 1.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ

бүлгийн дүнгээрээ 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 1.1 хувь, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2023 оны 10 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	2023 X / 2022 X	2023 X / 2022 XII	2023 X / 2023 IX
	хувь		
Ерөнхий индекс	**107.7**	**105.6**	**100.6**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	114.0	109.6	101.3
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.1	103.4	100.1
Хувцас, бөс бараа, гутал	107.3	105.9	100.2
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.4	103.4	101.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	107.5	105.1	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	112.1	112.1	100.9
Тээвэр	100.6	98.8	100.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	109.4	103.8	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	108.8	107.1	100.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	112.8	112.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	112.2	106.6	100.2

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2023 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна. Мөн өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 5.2 хувь, хонь, ямааны махны үнэ 11.1 хувь, гахайн махны үнэ 13.6, боловсруулсан, савласан махан бүтээгдэхүүн 23.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.5 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2023 оны 10 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.2 сая төгрөг болж, 12.5 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.0 сая төгрөг болж, 108.7 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 206.7 мянган төгрөг болж, 9.2 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.5 сая төгрөг болж, 90.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол эр ямааны үнэ 131.7 мянган төгрөг болж, 2.9 мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 10. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2023 оны 10 дугаар сард Түмэнцогт суманд хамгийн их буюу 2.5 сая төгрөг, Баяндэлгэр суманд хамгийн бага буюу 1.0 сая төгрөг байна.

ЗУРАГ 11. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2023 оны 10 сард, мянган төгрөг

Хивэгний үнэ 2023 оны 10 дугаар сард 26.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад хивэгний үнэ 8.5 мянган төгрөгөөр өссөн бол 1 боодол өвсний дундаж үнэ 8.1 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.3 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 12. БООДОЛТОЙ ӨВС, ХИВЭГНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 сард



<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

<u>Тооцох аргачлал:</u>

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

Хүнсний ногоо 1034.9 тн-ийг хурааж авсан байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 оны 10 дугаар сарын байдлаар төмс 609.4 тн, хүнсний ногоо 1034.9 тн, үр тариа 2.5 мянган тн, тэжээлийн ургамал 2.3 мянган тн, техникийн ургамал 645.0 тн, өвс 15.5 мянган тн-ыг хураан авсан байна.

Үр тариа 4.2 мянган га тариалсанаас 3.1 мянган га улаан буудай, 0.1 мянган га, арвай, 1.0 мянган га овьёос тариалсан байна.

ЗУРАГ 13. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га, эцсийн байдлаар



Өмнөх оны мөн үетэй харьцуулхад техникийн ургамал 160 (7.8%) га-аар буурсан бол төмс 17.7 (24.1 %) га-аар, хүнсний ногоо 18.7 (37.8%) га-аар, тэжээлийн ургамал 464.6 (58.9%) га-аар, үр тариа 551.0 (15.3%) га-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 14. ХУРААСАН УРГАЦ, тн



Өмнөх оны мөн үетэй харьцуулхад төмс 15 тн-аар буюу 2.6 дахин, хүнсний ногоо 15.5 тн-аар 2.5 дахин өссөн байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2023 оны эхний 10 сарын байдлаар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 27.0 хуиар өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 188.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 47.6 (33.9%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 36.7 (32.7%) тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 8.8 (53.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 148.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 36.7 (32.7%) тэрбум төгрөгөөр өсөхөд чулуун болон хүрэн нүүрс олборлолт 42.5 (38.4 дахин) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 7.8 (11.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, хайлуур жоншны баяжмалын олборлолтын биет хэмжээ 12.3 хувиас 19.0 дахин өсчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт талх, хэвийн боов, бялуу, хэрчсэн гурил, малын мах, бууз банш, монгол дээл, тэрлэг, гутал, бетон зуурмаг зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4.9 хувиас 3.1 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2022 X	2022 I-X	2023* X	2023* I-X
		тоо			
Уул уурхай, олборлох аж үйлдвэр					
Хүрэн нүүрс	мян.т	4.2	47.9	144.8	911.6
Цайрын баяжмал	мян.т	5.9	62.7	5.0	56.3
Төмрийн хүдэр	мян.т	-	-	-	1.5
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	-	40.9	-	-
Хайлуур жонш	мян.т	4.7	25.8	0.5	6.4
Хайлуур жоншны баяжмал	мян.т	3.4	16.6	2.4	18.6
Хайрга, шороо	мян.м3	-	-	0.8	1.2
Боловсруулах аж үйлдвэр					
Талх	т	39.8	414.4	57.3	500.7
Нарийн боов	т	8.6	78.1	5.3	59.9
Хэвийн боов	т	0.5	30.6	0.1	48.2
Бялуу	т	0.5	4.9	0.5	5.9
Хэрчсэн гурил	т	0.5	47.5	7.4	62.7
Малын мах	т	344.6	1 545.3	341.9	1 770.2
Цэвэр ус	мян.л	88.4	876.8	57.1	572.2
Бууз, банш	т	1.72	14.2	5.7	32.2
Самнасан хонины ноос	т	-	-	-	482.3
Эсгий	мян.м	-	2.5	-	1.3
Монгол дээл, тэрлэг	ш	113	2 035	245	2 135
Бэлтгэлийн хувцас /өмд, цамц/	ш	135	277	30	115
Гутал	хос	25	132	32	404
Бетон зуурмаг	м3	536.0	5 603.0	1 143.0	7 877.2

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2023 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 384.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 83.5 (27.8%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 70.9 (26.0%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн 10.2 (61.1%) тэрбум төгрөгөөр, усан хангамж хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх салбарын борлуулалт 0.8 (70.8%) төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сая.төг

Салбар	2022 I-X	2023*		2023* I-X / 2022 I-X
		I-X	Гадаад	
	тоо			хувь
Нийт дүн	**300 756.4**	**384 312.9**	**350 945.6**	**127.8**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	272 240.3	343 078.4	341 280.3	126.0
Боловсруулах аж үйлдвэр	16 617.3	26 765.0	9 665.3	161.1
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	10 806.0	12 603.3	-	116.6
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1 092.8	1 866.2	-	170.8

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 70.9 (26.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 70.7 (63.3 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг

Гадаад зах зээлд 2023 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 350.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 341.3 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 20.5 хувийг нүүрс олборлолтын салбар, 69.5 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 10.0 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувиараа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД

IV.1 ЭРҮҮЛ МЭНД

IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ

V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО

V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар

VI МӨНГӨ, БАНК

VI.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар

VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VIII ҮНЭ

VIII.а.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

VIII.а.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ

VIII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

IX ХӨДӨӨ АЖ АХУЙ

IX1 ТАРИАЛСАН ТАЛБАЙ, сумаар

IX2 ХУРААСАН УРГАЦ, сумаар

X АЖ ҮЙЛДВЭР

X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2021		2022		2023	2023 X / 2022 X
	X	I-XII	X	I-XII	X	
	тоо					хувь
Нийт дүн	**496**	**563**	**426**	**363**	**96**	**22.5**
Асгат	8	8	5	2	4	80.0
Баяндэлгэр	30	51	6	4	1	16.7
Дарьганга	15	34	7	3	3	42.9
Мөнххаан	8	38	40	36	8	20.0
Наран	11	6	9	10	4	44.4
Онгон	15	37	3	8	5	13.3
Сүхбаатар	48	48	24	19	10	41.7
Түвшинширээ	46	83	75	72	2	2.7
Түмэнцогт	19	30	12	11	3	25.0
Уулбаян	38	10	13	10	-	-
Халзан	4	15	1	1	-	-
Эрдэнэцагаан	32	32	15	12	3	20.0
Баруун-Урт	222	171	216	175	53	24.5

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Нийт дүн	**96**	**50**	-	**26**	**1**	**6**	**33**	**20**	**7**	**4**	**18**	**33**	**27**	**12**	**3**	**3**
Асгат	4	-	-	2	-	-	1	1	-	-	2	-	1	-	1	-
Баяндэлгэр	1	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дарьганга	3	3	-	3	-	-	-	-	-	-	1	1	1	-	-	-
Мөнххаан	8	3	-	-	-	2	2	1	-	3	-	2	2	3	-	1
Наран	4	1	-	-	-	-	2	1	-	1	1	1	1	1	-	-
Онгон	5	3	-	-	-	-	3	1	1	-	-	1	1	2	-	1
Сүхбаатар	10	7	-	1	-	-	-	7	2	-	3	4	-	1	1	1
Түвшинширээ	2	2	-	-	-	-	-	1	1	-	-	1	1	-	-	-
Түмэнцогт	3	1	-	1	-	1	1	-	-	-	-	1	-	1	1	-
Уулбаян	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	3	1	-	3	-	-	-	-	-	-	-	2	1	-	-	-
Баруун-Урт	53	28	-	15	1	3	23	8	3	-	11	20	18	4	-	-

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2021		2022		2023	2023 I-X / 2022 I-X
	I-X	I-XII	I-X	I-XII	I-X	
	тоо					хувь
Нийт дүн	**1 459**	**2 589**	**1 347**	**2 390**	**1 097**	**81.4**
Асгат	75	95	112	126	60	53.6
Баяндэлгэр	100	193	27	30	7	25.9
Дарьганга	107	177	135	136	85	63.0
Мөнххаан	22	96	103	103	13	12.6
Наран	70	98	131	137	72	55.0
Онгон	59	141	34	41	85	2.5 [1]
Сүхбаатар	68	122	156	161	65	41.7
Түвшинширээ	126	258	312	355	180	57.7
Түмэнцогт	63	125	63	64	23	36.5
Уулбаян	94	124	76	82	40	52.6
Халзан	17	39	33	33	22	-
Эрдэнэцагаан	68	103	91	95	91	100.0
Баруун-Урт	773	1 018	992	1 027	521	52.5

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2021		2022		2023	2023 I-X / 2022 I-X
	I-X	I-XII	I-X	I-XII	I-X	
	тоо					хувь
Нийт дүн	**329**	**607**	**676**	**761**	**409**	**60.5**
Асгат	46	52	90	104	51	56.7
Баяндэлгэр	5	35	4	6	3	75.0
Дарьганга	15	30	55	55	63	114.5
Мөнххаан	5	29	29	29	1	3.4
Наран	40	52	90	91	32	35.6
Онгон	8	49	-	17	47	-
Сүхбаатар	20	21	53	56	2	3.8
Түвшинширээ	37	81	122	153	47	38.5
Түмэнцогт	12	43	21	21	13	61.9
Уулбаян	20	37	36	38	22	61.1
Халзан	3	10	24	24	22	91.7
Эрдэнэцагаан	4	7	8	11	66	8.3 [1]
Баруун-Урт	114	161	144	156	40	27.8

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо					Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар												
	2022 I-X	2023 I-X				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах аж үйлдвэр	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Мэдээлэл, холбоо	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	бусад
		Бүгд	Байгууллага	Түр	Улирал													
Нийт дүн	**454**	**854**	**548**	**284**	**22**	**102**	**114**	**17**	**7**	**23**	**8**	**15**	**27**	**450**	**15**	**9**	**5**	**4**
Асгат	44	65	29	36	-	14	-	-	-	-	3	-	8	36	-	-	-	-
Баяндэлгэр	15	25	10	15	-	-	-	-	-	-	-	-	-	6	-	-	-	-
Дарьганга	15	139	96	43	-	11	-	1	-	-	-	-	7	86	8	7	3	-
Мөнххаан	37	44	22	17	5	-	-	-	-	4	-	-	-	40	-	-	-	-
Наран	23	80	33	40	7	2	-	1	-	1	-	-	-	72	1	-	-	-
Онгон	14	15	11	4	-	-	-	1	-	6	-	-	-	6	2	-	-	-
Сүхбаатар	49	13	13	-	-	5	-	3	-	1	-	-	1	-	1	-	2	-
Түвшинширээ	18	91	53	33	5	13	-	6	-	-	2	-	8	56	-	-	-	2
Түмэнцогт	18	27	27	-	-	-	-	-	-	-	-	-	-	27	-	-	-	-
Уулбаян	22	37	15	22	-	28	-	-	-	-	-	-	-	-	2	2	-	2
Халзан	19	15	11	2	2	-	-	-	-	-	-	15	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	19	180	131	46	3	6	114	5	7	2	-	-	-	46	-	-	-	-
Баруун-Урт	161	123	97	26	-	23	-	-	-	9	3	-	3	75	1	-	-	-

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2021 I-X		2022 I-X		2023 I-X	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**26 497**	**9 310.8**	**26 976**	**9 285.4**	**25 931**	**10 711.0**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	**9 220**	**5 918.4**	**6 952**	**5 693.4**	**5 086**	**6 886.8**
Нийгмийн халамжийн тэтгэвэр	**1 256**	**3 580.8**	**1 340**	**3 656.8**	**1 483**	**4 114.6**
Нийгмийн халамжийн тэтгэмж	**2 179**	**1 649.5**	**2 299**	**1 717.7**	**2 482**	**2 611.2**
Асаргааны тэтгэмж	**1 135**	**922.0**	**1 181**	**927.1**	**1 259**	**1 752.1**
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	641	474.6	677	467.0	212	300.3
Байнгын асаргаа шаардлагтай ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	225	164.1	223	156.1	757	974.2
Байнгын асаргаа шаардлагтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	225	251.8	236	265.2	248	412.6
